



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017. оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан 2.4.11, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/51 дүгээр захирамж, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жуулчдыг бэлэн мөнгөний эрсдэлээс хамгаалах, аюулгүй аялах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын нийтийн тээврээр зорчих, үзвэр, үйлчилгээний газруудад багцын үнээр үйлчлүүлэх боломжтой "Жуулчин" картыг үйлчилгээнд нэвтрүүлэх үүднээс картын заавар, хөнгөлөлт эдлэх худалдаа үйлчилгээний байгууллагуудын мэдээлэл, нийслэлийн газрын зураг болон жуулчдад шаардлагатай мэдээлэл бүхий аяллын хөтөч номыг хэвлүүлэх ажлыг "Колорфул" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг Төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн /Я.Сарангэрэл/-д даалгасугай.

2. Гэрээт ажлын хөлс болох 10.494.000 /арван сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

D. Batsum

Д.БАТСҮХ

